



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/71

Чингис хот

Иргэдийг татач авахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Шадар сайдын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 156 дугаар тушаалаар батлагдсан “Хот хоорондын зорчигч, тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт ажиллах хугацаанд Улаанбаатар хотод саатсан иргэдийг татан авах ажлыг 2021 оны 2 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 3 хоногийн хугацаанд зохион байгуулахад 2256050 /хоёр сая хоёр зуун тавин зургаан мянга тавь/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалт, халдвар хамгааллын хэрэгслийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Иргэдийг орон нутагт татан авах ажиллагааг халдвар хамгааллын дэглэмийг чанд баримталж зохион байгуулахыг ажлын хэсэг /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Хөрөнгө зарцуулалтад шаардагдах зардлыг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010206

02 Аймгийн Засаг даргын 2021 оны
..... дугаар сарын.....өдрийн А/71
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

Байгууллагын нэр	Зардлын нэр төрөл				Дүн
	Бичиг хэргийн зардал	Байрны зардал	Шатахууны зардал	Хоолны зардал	
Цагдаагийн газар	50000	300000	206150	375000	931150
Онцгой байдлын газар	300000			1024900	1324900
Дүн	350000	300000	206150	1399900	2256500